

БАЙНГЫН ОРШИН СУУХ (F-5)-ТАЙ ИРГЭНИЙ ЭХНЭР/НӨХӨР (F-2-3)

ОЛГОХ ХҮРЭЭ :

F-2-3: Байнгын оршин суух виз (F-5) -тэй иргэний эхнэр/нөхөр

Байнгын оршин суух виз (F-5) -тэй иргэний эхнэр/нөхрийн ангиллын визээр Монгол Улсаас БНСУ-д зорчихыг хүсч буй иргэн Солонгосын Виз Мэдүүлгийн Төвөөр дамжуулан виз мэдүүлнэ. Та нэг удаагийн, нэг жил хүртлэх виз мэдүүлэх боломжтой. Виз шалгагдах явцад БНСУ-ын ЭСЯ-аас нэмэлт бичиг баримтыг шаардах боломжтой.

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТУУД

1. Виз мэдүүлгийн маягт (Сүүлийн 6 сарын дотор авахуулсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг)
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь (Виз мэдүүлж буй өдрөөс хойш хамгийн багадаа 6 сарын хүчинтэй байх)
3. Цагдаагийн газрын тодорхойлолт (18-аас дээш, 60-аас доош насны анх удаа зорчиж буй иргэнд хамаарна)
4. Гэрлэлт бүртгэлийн лавлагаа
5. Эрүүл мэндийн тодорхойлолт (Виз мэдүүлэх өдрийг хүртэл 6 сарын дотор олгосон байх)
 - Эмнэлэг ба түүнтэй ижил түвшний байгууллага, Эрүүл мэндийн төвөөс олгосон байх
 - Эрүүл мэндийн ерөнхий үзүүлэлтүүдээс гадна сэтгэцийн өвчин, БЗХӨ, ДОХ, Сүрьеэ өвчний мэдээллийг агуулсан байх

УРИГЧ ТАЛЫН БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТУУД

1. Урилга (Хавсралт маягтын дагуу) Урилган дээр хувийн тамгаа дарж, Тамганы гэрчилгээний эх хувийг хавсаргах (Нотариатаар баталгаажуулах)
2. Гэрлэлтийн байдлын талаарх дэлгэрэнгүй анкет (Хавсралт маягтын дагуу)
3. Батлан даалтын бичиг (Хавсралт маягтын дагуу, Батлан даах хугацаа: БНСУ-ын хилээр нэвтэрсэн өдрөөс эхлээд 2 жил)
4. Гадаад иргэний оршин суух үнэмлэхийн хуулбар
5. Гэрлэлтийн байдлыг нотлох бичиг баримт (Байнгын оршин суугчийн харьяа төрийн байгууллагаас олгосон бичиг баримт)
6. Уригчийн санхүүгийн чадвар нотлох бичиг баримт
 - Орлого нотлох тодорхойлолт (Татварын Ерөнхий Газар), Ажлын газрын тодорхойлолт, Дансны хуулга зэрэг зээл төлбөр мэдээллийн лавлагаа (БНСУ-ын Банкны Холбооноос авах)

ø Өөрийн болон хамт амьдарч буй шууд холбоо хамааралтай гэр бүлийн гишүүд болон эхнэр/нөхөр (Уригдагч)-ийн виз мэдүүлэх өдрийг хүртэлх сүүлийн 1 жилийн орлогын нийт хэмжээ нь өнгөрсөн онд БНСУ-ын Төв банкнаас зарласан нэг хүнд ногдох үндэсний нийт орлого (GNI)-ын хэмжээнээс дээш байх
 ø 2021 оны байдлаар нэг хүнд ногдох (GNI) нь 40,247,000 вон
 ø Хамт амьдарч буй гэр бүлийн гишүүдийн тоо 3 ба түүнээс доош байх тохиолдолд GNI-ийн 70%-аас дээш байх (28,172,900 вон)

<p>7. Оршин суух хаягийг нотлох бичиг баримт</p> <ul style="list-style-type: none">• Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар, Түрээсийн гэрээ (Хамаарах тохиолдолд)
<p>8. Гэрлэлт бүртгүүлсэн талуудын цагдаагийн газрын тодорхойлолт</p>
<p>9. Гэрлэлт бүртгүүлсэн талуудын эрүүл мэндийн тодорхойлолт (Виз мэдүүлэх өдрийг хүртэл 6 сарын дотор олгосон байх)</p> <ul style="list-style-type: none">• Эмнэлэг ба түүнтэй ижил түвшний байгууллага, Эрүүл мэндийн төвөөс олгосон байх• Эрүүл мэндийн ерөнхий үзүүлэлтүүдээс гадна сэтгэцийн өвчин, БЗХӨ, ДОХ, Сүрьеэ өвчний мэдээллийг агуулсан байх
<p>10. Дахин гэрлэж буй тохиолдолд гэрлэлт цуцлалтын лавлагаа, Эсхүл шүүхийн шийдвэрийн хуулбар</p>

ø Анхаарах зүйлс

- Байнгын оршин суух виз (F-5) авснаас хойш 3 жилийн хугацаа өнгөрсөн байх